ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 27 өдөр Дугаар 3/12 Сайншанд

Эрүүл иргэн дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дах хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 02/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх "Тогтвортой хөгжсөн Сэврэй-2028" үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих "Эрүүл иргэн" дэд хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн сумын хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, хэрэгжилтийн явц үр дүнг жил бүр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга /Б.Батсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА Ч.ОГТБИШ

4625013024

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн
3/12 дугаар тогтоолын нэгдүгээр
хавсралт

ЭРҮҮЛ ИРГЭН ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Эрүүл мэндийн салбарын статистик үзүүлэлт, Монгол Улсын тогтвортой үзэл баримтлал 2030, Өмнөговь аймгийн Засаг даргын 2025-2028 оны "Өсөлттэй Өмнөговь" эрүүл мэндийн салбарын зорилт 2.2 дахь заал, Сумын хөгжлийн дунд хугацааны бодлого, Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн "Эрүүл мэндийн салбарын өсөлт" 2.30 дахь заалтын хэрэгжилтийг хангах нь "Эрүүл иргэн" дэд хөтөлбөрийн үндэслэл болно

Хоёр. Хэрэгцээ шаардлага

Сэврэй сум нь 2024 оны жилийн эцсийн байдлаар суурин хүн ам нь 1851, хөдөлгөөнт хүн ам нь 500 гаруй болсон бөгөөд суурин хүн амын 937 буюу 47,6% нь эрэгтэй, 914 буюу 46.8% нь эмэгтэй хүйс эзэлж байна. Аймгийн хүн амын дундаж наслалт 2024 оны байдлаар 73.4, улсын дундаж 71.5-тай бөгөөд сумын хүн амын дундаж наслалт 73.5 байна. Хүн амын дундах сүүлийн 5 жилийн тэргүүлэх өвчлөлд 1-рт Зүрх судасны эрхтэн тогтолцооны эмгэг, 2-рт амьсгалын замын эмгэг, 3-рт Хоол боловсруулах замын эмгэг, 4-рт Бөөр шээсний замын эмгэг, 5-рт мэдрэлийн эрхтэн тогтолцооны эмгэг бүртгэгдсэн байгаа бөгөөд мөн хавдрын өвчлөл тогтвортой буурахгүй жилдээ хавдраар 1-2 иргэн илэрч одоо хяналтад 6 иргэн хорт хавдрын өвчлөлийн хяналтад байгаа зэрэг нь иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалт хангалтгүй байгаатай шууд хамааралтай байна.

Өсвөр болон бага насны хүүхдүүдийн дундах 2024 оны "Жаргалтай ирээдүй" үзлэгийн үр дүнд нийт үзлэгт хамрагдсан хүүхдүүдийн 67.5 % нь шүд амны хөндийн өвчтэй байгаа нь хүүхдүүдийн дунд амны хөндийн эрүүл ахуйн мэдлэг хангалтгүй, шүдээ зөв арчлах дадал хэвшил бүрэн төлөвшөөгүй улмаас шүд цоорох өвчлөл өндөр байна. Хүүхдийн шүдний цоорол нь амь насанд аюултай чих хамар хоолойн болон эрүү нүүрний үрэвсэлт өвчний шууд шалтгаан болоод зогсохгүй хүүхдийн суурь өвчин амьсгал болон хоол боловсруулах замын өвчлөлд хүргэх дам шалтгаан болж байна.

Амьдралын эрүүл зөв хэв маягаас үүдэлтэй сэргийлж болох өвчлөл нэмэгдэж байгаа нь иргэдээ эрүүл зөв зан үйлд сургах, хөдөлгөөн эрүүл мэндийг дэмжих, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зайлшгүй шаардлага бий болоод байна.

Үүнд: 2024 оны байдлаар Артерийн даралт ихсэлт- 46, Чихрийн шижин –6 иргэн, Хөх умайн хүзүүний хавдрын өөрчлөлттэй-8 эмэгтэй , Хүүхдүүдийн дундах 2-14 насны шүдний өвчлөл – 67,5%-тай байна .

Иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалах үүрэг бүхий эрүүл мэндийн ажилтнуудын мэргэжлийн мэдлэг ур чадварыг хөгжүүлэх, ур чадвар гарган үр бүтээлтэй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн ажилтнуудыг урамшуулан дэмжих замаар эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах хэрэгцээ нэмэгдэж байна.

Гурав. Хөтөлбөрийн зорилго

Өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх тогтолцоог орон нутагтаа бэхжүүлэн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн эрүүл мэндийг дэмжин амьдралын чанарыг сайжруулах замаар "**ЭРҮҮЛ ИРГЭН**"-г бий болгоход оршино.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилт

Зорилт 1. Сумын иргэдийн эрүүл мэндийн байдалд дүн шинжилгээг хийж цахим мэдээллийн санг бүрдүүлэн, нотолгоонд суурилсан иргэдийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулна.

Зорилт 2. Иргэдийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд жил бүр хамруулан эрүүлжүүлэн ажиллана.

Зорилт 3. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж эрүүл зөв зан үйлийг төлөвшүүлэн хүн амыг амьдралын хэв маягаас үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлж эрүүл насжилтыг уртасгана.

Зорилт 4. Иргэдийн шүд амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангаж, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар хүүхдийн шүдний өвчлөлийн тархалт цоорлын эрчмийг бууруулж эрүүлжүүлэн ажиллана.

Зорилт 5. Эрүүл мэндийн ажилтнуудын мэргэжлийн мэдлэг ур чадварыг хөгжүүлэх, үр бүтээлтэй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтнийг урамшуулан дэмжих замаар эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Тав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

5.1 Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

5.1.1 Айл өрх болон иргэдийн эрүүл мэндийн байдалд судалгаа хийж иргэдийн дундах тэргүүлэх өвчлөлийг илрүүлэн статистик үзүүлэлттэй харьцуулан судалж дүн шинжилгээ хийж мэдээллийн санг бүрдүүлэх

5.1.2 Иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлэх, иргэдийн сэргийлж болох өвчлөл эндэгдлийг бууруулахад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах

5.1.3 Иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүртгэл мэдээлэл тандалт хяналтын тогтолцоог сайжруулах

5.2 Хөтөлбөрийн 2 дүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

5.2.1 Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдах иргэдийн судалгааг жил бүр шинэчлэн гаргах

5.2.2 Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг шинжилгээг зохион байгуулан хамрагдалтыг нэмэгдүүлэн мэдээллийн санг бүрдүүлэх

5.2.3 Эрт илрүүлэг үзлэг шинжилгээгээр өөрчлөлттэй гарсан иргэдийг хяналтдаа авч эмчлэн эрүүлжүүлэх, шаардлагатай иргэдийг дээд шатлалд илгээн эргэх тогтолцоог бэхжүүлэх

5.2.4 Иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оношилгоо эмчилгээний дэвшилтэт аргыг нэвтрүүлэн нутагшуулах

5.2.5 Иргэдийн эрүүл мэндийн оношилгоо эмчилгээний дараах хяналтыг тогтмолжуулан давтан үзлэгт графикийн дагуу хамруулах

5.2.6 Зорилтот бүлгийн иргэдэд "Эрүүл мэндийн цогц" үзлэгийг хуваарийн дагуу зохион байгуулж, сэргээн засах, хөдөлгөөн засах зэрэг шаардлагатай тусламж үйлчилгээг өргөжүүлэн үзүүлэх

5.2.7 Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн эмч нарын явуулын багийг дайчлах

5.2.8 Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгийг үе шаттайгаар нэмэгдүүлж тусламж үйлчилгээний нотолгоонд суурилсан үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх

5.3 Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

5.3.1 Албан байгууллага, аж ахуй нэгж, ард иргэд айл өрхийн дундах амьдралын буруу хэв маяг, эрсдэлт хүчин зүйлийн судалгаа хийж нотолгоонд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх

5.3.2 Судалгаанд суурилсан хэрэгцээг тодорхойлж сургалт сурталчилгааны төлөвлөгөөг гаргах

5.3.3 Нотолгоонд суурилсан зорилтот бүлгийг тодорхойлон тэдэнд чиглэсэн сургалт сурталчилгаа эрүүл мэндийн боловсрол олгох олон талт үйл ажиллагааг төрөл бүрийн арга сувгаар зохион байгуулан үр дүнг тооцох

5.3.4 Эцэг эх ,сургууль, цэцэрлэгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр мэдлэг хандлагыг дээшлүүлж эрүүл зан үйлийг төлөвшүүлэх сургалт сурталчилгаа нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах

5.3.5 Амьдралын буруу хэвшлээс үүссэн өвчлөл болох Артерийн даралт , чихрийн шижин, хөх умайн хүзүүний хавдар, элэгний ВС вирусийн халдварын өвчлөлд дүн шинжилгээ хийж иргэдийг зөв дадалд /зөв хооллолт, хөдөлгөөн эрүүл мэнд, эмийн зохистой хэрэглээ / сурган эрүүлжүүлэх

5.4 Хөтөлбөрийн 4 дүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

5.4.1 Шүдний кабинетыг тохижуулан тоног төхөөрөмж эм эмнэлгийн хэрэгслээр ханган үйл ажиллагааг тогтмолжуулах

5.4.2 Эрүүл мэндийн байгууллагын амны хөндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн, шүдний гэрээт эмнэлэгтэй хамтран ажиллах / мэргэшсэн чадварлаг хүний нөөцөөр хангагдах /

5.4.3 Хүүхэд эцэг эх гэр бүлийн гишүүд болон хамт олны оролцоотойгоор шүд цоорох өвчин түүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх, амны хөндийн эрүүл мэнддээ хяналт тавих эрүүл зан үйлийг төлөвшүүлэх судалгааг хийх

5.4.4 Сургуулийн өмнөх болон сургуулийн байгууллагыг түшиглэн хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн талаарх мэдлэг хандлагыг сайжруулж эрүүл ахуйн дадал хэвшлийг төлөвшүүлэн зөвлөгөө зөвлөмжийг өгч анги бүр шүд угаах буланг бий болгон шүд тогтмол угааж хэвших

5.4.5 Бага насны хүүхдийн шүдийг бэхжүүлэхэд эхийн хэвлийд ургийн бойжилтын үеэс эхлэн эрүүл зөв хооллолт сүү цагаан идээ зэрэг уламжлалт аргын хэрэглээг сурталчлах

5.4.6 Хүүхдийн шүдний урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулан илрүүлсэн өвчлөлийг эмчлэн эрүүлжүүлэх ажлыг бусад байгууллага, эцэг эхчүүдийн идэвх санаачлагсад тулгуурлан үр дүнтэй , үе шаттай хамтран зохион байгуулж ажиллах

5.4.7 Шүдний өвчлөлийн бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн сантай болох

5.5 Хөтөлбөрийн 5 дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

5.5.1 Эмч эмнэлгийн мэргэжилтэн ажиллагсдыг дээд шатлалд болон ажлын байранд сургах нөхцөл бололцоогоор ханган мэдлэг ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх

5.5.2 Тогтвор суурьшилтай үр бүтээлтэй ажиллаж байгаа эмч эмнэлгийн ажилтнуудыг урамшуулан дэмжин ажиллаж, Эрүүл мэндийн ажиллагсдын тэмдэглэлт өдөр /Эмч нарын өдөр, сувилагч тусгай мэргэжилтний өдөр, эмнэлгийн ажиллагсдын өдөр/ тэднийг алдаршуулах урамшуулах үйл ажиллагааг зохион байгуулах

Зургаа Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа

Хөтөлбөрийг сумын хэмжээнд 2025-2028 онд үе шаттай хэрэгжүүлнэ

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ .

7.1.Улсын төсөв.

7.2 Орон нутгийн төсөв.

7.3 Орон нутгийн хөгжлийн сан

7.4 Олон улсын төсөл , хөтөлбөр .

7.5 Аж ахуйн нэгж байгууллагын хандив.

7.6 Бусад эх үүсвэр

Найм. Хөтөлбөрөөс хүлээгдэж буй үр дүн

8.1 Иргэдийн эрүүл мэндийн байдалд судалгаа хийгдэн иргэдийн эрүүл мэндийн байдал 5 бүлгээр тодорхойлогдон, эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа сайжирсан байна.

8.2 Иргэдийн дундах тэргүүлэх 5 өвчлөл тодорхойлогдон иргэдийн дундах өвчлөл жил ирэх тутам буурсан байна.

8.3 Эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдсэнээр иргэдийн дундах өвчлөл буурч иргэдийн эрүүл мэндийн байдал сайжирч дундаж наслалт нэмэгдсэн байна.

8.4 Иргэд урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг шинжилгээндээ жил бүр хамрагдсанаар өвчний эрт үеийн илрүүлэлт сайжирч өвчний хүндрэл нас баралт буурсан байна.

8.5 Иргэдийн эрүүл мэндийн боловсрол сайжирснаар иргэдийн дундах зөв зан үйл дадал хэвшил тогтмолжиж амьдралын хэв маягаа өөрчилж эрүүлжсэн байна.

8.6 2-16 насны хүүхдийн шүдний өвчлөл буурч амны хөндийн эрүүл ахуй сайжирч хүүхдийн архаг болон суурь өвчлөлөөс сэргийлэх боломж бүрдсэн байна.

8.7 Сургуулийн өмнөх болон сургуулийн байгууллагыг түшиглэсэн хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн талаарх мэдлэг хандлага сайжирсан эрүүл ахуйн дадал хэвшлийг төлөвшсөн анги бүр шүд угаах буланг бий болгон шүд тогтмол угааж хэвшсэн байна.

8.8 Эрүүл мэндийн ажилтнуудын мэргэжлийн мэдлэг ур чадвар нэмэгдэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирч, эмнэлгийн эмч ажиллагсдын урамшууллын тогтолцоо тогтмолжин ажиллагсдын сэтгэл ханамж ажлын үр дүн дээшилсэн байна.

Ес. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт

9.1 Хөтөлбөрийн үйл ажиллагааны нэгдсэн удирдлага зохицуулалтыг Сумын Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлнэ.

9.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах мэдээллээр хангах удирдлага арга зүйгээр хангаж хэрэгжүүлэх хяналт тавих тайлагнаж ажиллах чиг үүргийг Эрүүл мэндийн төв хариуцан гүйцэтгэнэ.

Арав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ үнэлгээ

10.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг ЗДТГ-н хяналт-шинжилгээ үнэлгээний алба жил бүр хийж үр дүнг үнэлнэ.

10.2 Хэрэгжилтийг жил бүр өссөн дүнгээр дүгнэж ажиллана .

10.3 Хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүрийн 12 сард багтаан сумын ИТХ-д тайлагнана.

Арван нэг. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин			
				2025	2026	2027	2028
1	Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамрагдсан иргэдийн хувь	Хувь	60%	65 %	70 %	75%	80 %
2	Дундаж наслалт	Тоо	73,5	73,6	73,7	73,8	73,9
3	Артерийн даралт өвчний үзлэгт хамрагдсан иргэдийн тоо хувь	Хувь	100%	100%	100%	100%	100%

4	Чихрийн шижин өвчний үзлэгт хамрагдсан иргэдийн тоо хувь	Хувь	97,3%	98%	100%	100%	100%
5	Хөх умайн хүзүүний хавдрын үзлэгт хамрагдсан иргэдийн тоо хувь	Хувь	100%	100%	100%	100%	100%
6	ЭМБ / зөв зан үйлд сургах / олгох сургалт сурталчилгаа аян өдөрлөгт хамрагдсан иргэдийн тоо хувь	Тоо Хувь	404 /20%/	500 25%	600 30%	700 /35%	1000 40 %
7	Зөв зан үйл дадалд хэвшүүлсэн иргэдийн тоо хувь	Хувь	20%	25%	30%	35%	40%
8	2-6 хүртэлх насны хүүхдийн дунд шүд цооролтын тархалтын хувь	Хувь	81%	75%	65%	55%	50%
9	6-16 насны хүүхдийн дунд шүд цоорлын тархалтын хувь	Хувь	67,5%	65%	60%	50%	45%
10	Шүд угаах булантай болсон ангийн тоо	Тоо	4	8	10	11	12/
11	Урамшуулалд хамрагдсан эмнэлгийн ажиллагсдын тоо	Тоо Хувь	2 10%	3 30%	5 30%	7 35%	8 40%

-oOo-

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн
3/12 дугаар тогтоолын хоёрдугаар
хавсралт

ЭРҮҮЛ ИРГЭН ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч : Эрүүл мэндийн төвийн эрхлэгч

Гишүүдэд: Ерөнхий боловсролын сургуулийн захирал
20 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
Ахмадын хорооны дарга
Эрүүл мэндийн төвийн их эмч
Эрүүл мэндийн төвийн Нийгмийн ажилтан
Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтэн
Засаг даргын Тамгын газрын Биеийн тамирын арга зүйч

Нарийн бичиг: Эрүүл мэндийн төвийн Статистикийн мэргэжилтэн

-oOo-